

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЯНАЛТАНД БУЙ ХУУЛЬ
ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

Дундговь аймагт 2019 оны хагас жилийн байдлаар хяналтанд хэрэгжиж буй 34 шийдвэрийн 47 заалтыг хяналтанд авч хэрэгжүүлж биелэлт **81,0%** хэрэгжилттэй байна.

100 хувь буюу (90-100) бүрэн хэрэгжсэн- 19

70 хувь буюу (50-89) хэрэгжих шатанд – 19

30 хувь буюу (10-49) хэрэгжилт хангалтгүй- 3

0 хувь буюу (0-9) хэрэгжээгүй – 0

Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй – 6 заалт байна.

Хэрэгжилт гаргах нийт заалтын тоо		47
Бүрэн хэрэгжсэн	100%	19
Хэрэгжих шатанд	70%	19
Хэрэгжилт хангалтгүй	30%	3
Хэрэгжээгүй	0%	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	6
Хэрэгжилтийн дундаж		81%

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тусгай удирдамж, шалгуур үзүүлэлтийг урьдчилан гаргаж холбогдох газруудад хүргүүлэн, хяналт-шинжилгээ үнэлгээний ажлын явцад болон дууссаны дараа ажил сайжруулах чиглэлээр тайлан, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох газруудад хүргүүлж хэрэгжилтийн явцад хяналт тавьж заавар, зөвлөмж нэгдсэн удирдлагаар хангаж ажилласны үр дүнд бодлогын хэлтэс, мэргэжилтнүүд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хугацаандаа тайлагнах зэргээр ажлын чанар, гүйцэтгэл сайжирч байна.

Цаг хугацаанаас хамаарч үнэлэх боломжгүй буюу удаашралтай хэрэгжиж байгаа 6 заалтаас санал санаачилга гарвал дэмжиж ажиллах 2 заалт, хэрэгжиж эхэлж байгаа 1 заалт, дээд газраас шалтгаалсан 3 заалт байгаа ба Ноолуур хөтөлбөрийн хэрэгжилт аймаг орон нутагт хэрэгжих боломж тааруу байна. Нэгдүгээр үе шатны хүрээнд 2018-2019 онд нийт түүхий эдийн 40 хувийг дотоодын үйлдвэрийн хэрэгцээнд авч, ноолуурын үйлдвэрлэл, худалдаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн оновчтой дэмжлэг үзүүлэх замаар үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, бүрэн боловсруулалтын түвшинг ахиулах, кластерыг дэмжих, брэндийг таниулах, түүхий эдийн

чанар, бэлтгэлийн тогтолцоог сайжруулна гэсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхой бус, мэдээлэл дутмаг байгаад шат шатандаа анхаарч ажиллах шаардлагатай байна.

Цаашид анхаарах санал зөвлөмж

1. Засгийн газрын тогтоолоор батлагдсан Төрөөс баримтлан бодлого болон Үндэсний хөтөлбөр, стратегийн хүрээнд батлагдан гарсан даруйд харьяа дээд газраас чиглэл авах тухайн жилд хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган биелэлтийг тооцож ажиллан тайлагнах
2. Хугацаа болоогүй болон удаашралтай хэрэгжиж байгаа заалтыг нэн даруй судалж хэрэгжилтийг эрчимжүүлэх үйл ажиллагааг төлөвлөгөө гарган биелэлтийг тооцож зохион байгуулах
3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэгддэг тул шаардлага хангахуйц хэрэгжилт ирүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС